



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/419

Чингис хот

Коронавируст халдвар /Ковид-19/-ын болзошгүй эрсдэлийг бууруулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх аймгийн нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хувийн хамгаалах хэрэгсэл худалдан авахад 15,000,000 (арван таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэргэжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011983

Аймгийн Засаг даргын 2021 оны  
...09... дугаар сарын 06 өдрийн 07/4/19  
дугаар захирамжийн хавсралт

Коронавируст халдвар /Ковид-19/-ын болзошгүй  
эрсдэлийг бууруулахад шаардлагатай зардлын тооцоо

	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Шаардлагатай хамгаалах хэрэгсэл	
				Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	1 удаа өмсгөл	ширхэг	10000	5000	500,00,00
2	Нүүрний хаалт	ширхэг	2000	500	1,000,000
3	Үзлэгийн бээлий	Хос	650	10000	6,500,000
4	Түрийтэй улавч	Хос	2500	200	500,000
5	Жавелион	фл	80000	25	2,000,000
					<b>15,000,000</b>